

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ДАВААГИЙН ЦЭНДСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ЁСНЫ ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ							
1 (11.1)	Гаалийн хяналтад эрсдэл тооцсон байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	Нэг. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро, микро түвшний 72 судалгааг хийж гүйцэтгэсэн: · Гадаад худалдааны орчны судалгаа (2018-2024 он); · Гаалийн харилцаанд оролцогчдын хууль сахилтыг тодорхойлох зорилгоор 2024 оны импортын гаалийн бүрдүүлэлтэд хийсэн судалгаа (150 ААНБ, 149 иргэний жагсаалтыг гаргаж 2025.01.21, 02-1/320 тоотыг Татварын ерөнхий газарт хүргүүлж, үр дүнгээр 133 шалгуур үзүүлэлтийг ЭУП-д оруулсан); · Нефтийн бүтээгдэхүүний судалгаа 2019-2024 он; · Гаалийн хяналтын төлөвийн мэдээ 2024 он; · Эрсдэлийн шалгуурын судалгаа 2024 он; · Шалгалтын үр дүнгийн саналд хийсэн судалгаа 2023-2024 он; · Хоёрдмол зориулалттай бараа (dual-use goods)-ны судалгаа; · Бэлэн мөнгөний хяналт цэсэнд бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ, 2024 он; · Зорчигчийн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл дүн шинжилгээ, 2024 он; · Сангийн яаманд “Гаалийн байгууллагын ерөнхий гүйцэтгэл” 1995-2024 он; · Сангийн яаманд “Гүйцэтгэлийн шинжилгээ” 2005-2024 он; · Сангийн яаманд “Гүйцэтгэлийн дэлгэрэнгүй” 2018-2024 он (ААН, иргэнээр); · Татварын нэхэмжлэл дахин үүсгэж, импортын гаалийн үнийг бууруулсан болон өсгөсөн гаалийн бүрдүүлэлтэд дүн шинжилгээ; · УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд “Гадаад	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэж бууруулна” гэсэн заалтын биелэлтэд тооцох аргачлалыг; - Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах 25 аж ахуйн нэгжийн судалгаа (2025.02.18,01800/39 БДШГ-т хүргүүлсэн); - Кайс программ-Эрсдэлийн удирдлага-Зорчигч онилох модуль-Бэлэн мөнгөний хяналт цэсэнд бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ; - Гаалийн бүрдүүлэлтийн 2024 оны импортын бүрдүүлэлтийн дүн шинжилгээ; - Цахим худалдааны судалгаа; - Улс хоорондын шуудан илгээмжийн эрсдэлийн судалгаа; - Эрсдэлийн шалгуурын судалгаа гэх мэт. Хоёр. БДШГ-т “Аж ахуйн нэгжийн хууль сахилт, эрсдэлийн шалгуурын ерөнхий ойлголт”, “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг нөхөн бичихэд гарсан алдаа болон хэрхэн нөхөн бичих талаар илтгэл бэлтгэж, арга зүйн зөвлөмж өгч, Эрсдэлийн удирдлагын программыг шинэчлэн хөгжүүлэх төслийн талаар мэдээлэл өгч, хамтарсан уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр хийж, харилцан санал солилцон ажилласан. Гурав. Татварын ерөнхий газартай хамтарсан эрсдэл тооцох чиглэлээр 4 удаа уулзалт хийж, дараах мэдээллийг хүргүүлж, 518 иргэн, ААН-ийн хууль сахилтыг тодорхойлсон: - Монгол Улсын 2024 оны импортод барааны тоо, нэр төрөл, статистик дүн, татварын дүнгээр хамгийн их хувь эзэлсэн 150 аж ахуйн нэгж, байгууллага, 149 иргэн (2025.01.21, 02-1/1/320); - Хууль бус худалдаатай тэмцэх (2025.03.14, 02-1/1/1033) хүрээнд дотоодын зах зээлд алт, мөнгөн эдлэл худалдаалдаг иргэн; - БНХАУ-ын ГЕГ-аас Итгэмжлэгдсэн Аж Ахуйн Нэгжийн эрх олгосон компанитай гадаад худалдаа эрхэлдэг Монгол талын хүлээн авагч 218 аж ахуйн нэгж. Хүрсэн үр дүн: - Судалгааны үр дүн болон ГЕГ-ын БЦТ, БДШГ, харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажиллаж, КАИС-ийн Эрсдэлийн удирдлагын		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь																																																																															
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин																																																																																			
0	1	2	3	4	5				6	7																																																																														
					программд тайланд хугацаанд 62 хяналтын хуудсаар нийт 587 эрсдэлийн шалгуур боловсруулж, батлуулан, оруулсан. <table><thead><tr><th rowspan="2">ЭУ-ын профайл (2025.01.01-2025.06.10)</th><th colspan="3">Хяналтын хуудас тоо</th><th rowspan="2">Хувь</th><th colspan="3">Боловсруулсан шалгуур тоо</th><th rowspan="2">Хувь</th></tr><tr><th>импорт</th><th>экспорт</th><th>нийт</th><th>импорт</th><th>экспорт</th><th>нийт</th></tr></thead><tbody><tr><td>Заавал шалгах шалгуур</td><td>16</td><td></td><td>16</td><td>25.81</td><td>160</td><td></td><td>160</td><td>27.26</td></tr><tr><td>Зөвшөөрөгдсөн шалгуур</td><td>15</td><td></td><td>15</td><td>24.19</td><td>268</td><td></td><td>268</td><td>45.66</td></tr><tr><td>Өндөр эрсдэлийн шалгуур</td><td>12</td><td>1</td><td>13</td><td>20.97</td><td>53</td><td>14</td><td>67</td><td>11.41</td></tr><tr><td>Санамсаргүй сонголтын шалгуур</td><td>2</td><td></td><td>2</td><td>3.23</td><td>2</td><td></td><td>2</td><td>0.34</td></tr><tr><td>Үл хамаарах шалгуур</td><td>10</td><td></td><td>10</td><td>16.13</td><td>74</td><td></td><td>74</td><td>12.61</td></tr><tr><td>Хассан шалгуур</td><td>5</td><td>1</td><td>6</td><td>9.68</td><td>15</td><td>1</td><td>16</td><td>2.73</td></tr><tr><td>Grand Total</td><td>60</td><td>2</td><td>62</td><td>100.00</td><td>572</td><td>15</td><td>587</td><td>100.00</td></tr></tbody></table> · Эрсдэлийн удирдлагад суурилсан үр дүнгээр БДШГ-т 36 ААН-ийн мэдээллийг хүргүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог ханган ажилласан. БДШГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/32, 01-6/12, 01-6/18 дотоод зурвасаар ирүүлсэн бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдсан 71 ААН-д эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулсан. · Гаалийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газар хамтарсан эрсдэл тооцож, 518 хуулийн этгээдийн хууль сахилтыг тодорхойлж 391 аж ахуйн нэгж, иргэний бизнесийн үнэлгээг тодорхойлж, холбогдох эрсдэлийн шалгуурт оруулж (175 ААН, иргэн: 2025.02.03, 218: №07/348; 218 ААН, иргэн: 2025.06.07, 218: №07/1342; 2025.05.26, №07/1528), хууль ёсны худалдааг хөнгөвчлөх боломжийг бүрдүүлсэн.				ЭУ-ын профайл (2025.01.01-2025.06.10)	Хяналтын хуудас тоо			Хувь	Боловсруулсан шалгуур тоо			Хувь	импорт	экспорт	нийт	импорт	экспорт	нийт	Заавал шалгах шалгуур	16		16	25.81	160		160	27.26	Зөвшөөрөгдсөн шалгуур	15		15	24.19	268		268	45.66	Өндөр эрсдэлийн шалгуур	12	1	13	20.97	53	14	67	11.41	Санамсаргүй сонголтын шалгуур	2		2	3.23	2		2	0.34	Үл хамаарах шалгуур	10		10	16.13	74		74	12.61	Хассан шалгуур	5	1	6	9.68	15	1	16	2.73	Grand Total	60	2	62	100.00	572	15	587	100.00		
ЭУ-ын профайл (2025.01.01-2025.06.10)	Хяналтын хуудас тоо			Хувь	Боловсруулсан шалгуур тоо			Хувь																																																																																
	импорт	экспорт	нийт		импорт	экспорт	нийт																																																																																	
Заавал шалгах шалгуур	16		16	25.81	160		160	27.26																																																																																
Зөвшөөрөгдсөн шалгуур	15		15	24.19	268		268	45.66																																																																																
Өндөр эрсдэлийн шалгуур	12	1	13	20.97	53	14	67	11.41																																																																																
Санамсаргүй сонголтын шалгуур	2		2	3.23	2		2	0.34																																																																																
Үл хамаарах шалгуур	10		10	16.13	74		74	12.61																																																																																
Хассан шалгуур	5	1	6	9.68	15	1	16	2.73																																																																																
Grand Total	60	2	62	100.00	572	15	587	100.00																																																																																
2 (11.2)	Хууль сахилтын удирдлагын хэрэгжилтийг хангах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	60%	Нэг. Тайлант хугацаанд 42,273 гаалийн мэдүүлгийг засварт буцаасан нь нийт бүрдүүлэлтийн 9.2%-ийг эзэлж байна. Үүнд: 38,469 мэдүүлгийг баталгаажихаас өмнө, 3,804 мэдүүлгийг баталгаажсаны дараа тус тус засварт буцаасан байна. · Гаалийн хяналтын “Ногоон” төлөвийн 15 мэдүүлгийг “Улаан” төлөвд өөрчилснөөс ШХГГ-т “Тодотгох тоо хэмжээ оруулах” шалтгаанаар 8 экспортын мэдүүлэг, УБГГ-т “Бүрдүүлэлтийн нэгдсэн төвөөс үнэ хэт бага гэх үндэслэлээр төлөв солив” зэрэг шалтгаанаар импортын 5 мэдүүлэг болон ЗҮГГ-т “БЦТ-өөс төлөв солих хүсэлт ирүүлсний дагуу төлөв солив” зэрэг шалтгаанаар импортын 4 мэдүүлэг, нийт “Ногоон” төлөвийн 15 мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн байна. Харин гаалийн хяналтын “Улбар шар” төлөвийн 10 мэдүүлгийг “Улаан” төлөвд өөрчилснөөс ШХГГ-т				01.01-06.10	100																																																																														

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					“Тодотгох тоо хэмжээ оруулах” шалтгаанаар 7 экспортын мэдүүлэг, УБГГ-т “ГУБ-ийн хуваарь солигдсон тул” шалтгаанаар импортын 1 мэдүүлэг болон СЭГГ-т “Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/422 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журмын 3.9-д заасны дагуу СЭГГ-ын даргын өгсөн чиглэлийн дагуу лабораторийн шинжилгээнд хамруулах зорилгоор төлөв өөрчлөв” зэрэг шалтгаанаар импортын 2 мэдүүлэг, нийт “Улбар шар” төлөвийн 10 мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн байна. - Гаалийн хяналтын ногоон төлөвт сонгогдсон 15, улбар шар төлөвт сонгогдсон 10, нийт 25 гаалийн мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн байна. - Тайлант хугацаанд зорчигчийн мэдээллийн санд 112 зорчигч бүртгэгдсэн. Нийт АПИС-ийн мэдээллээр 635,912 зорчигч бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өссөн (635,912/606,790). - Ухаалаг гарцын хэрэгжилттэй холбоотой улсын хилээр зорчигч, бараа тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн бүртгэлийг Гааль, татварын санхүүгийн мэдээллийн төвтэй хамтран, тухайн жолоочийн Зам, тээврийн хөдөлгөөнд оролцохдоо гаргасан зөрчил, тээврийн хэрэгслийн татвар төлсөн байдал зэргийг Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн сангаас татаж авах, хилээр нэвтэрсэн давтамжаар эрсдэл тооцох алгоритмыг ХБГ, МТГ-тай хамтран гаргаж, холбогдох программын шийдлийг бий болгосон. Хоёр. БДШ оруулах шалгалтын үр дүнгийн саналд дүн шинжилгээ хийж БДШГ-тай уулзалт хийж, цаашид сайжруулах чиглэлээр санал солилцсон. Хүрсэн үр дүн: - Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт гаалийн бүрдүүлэлтийн 60%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. - Зорчигчийн мэдээллийн санд 112 зорчигч бүртгэгдсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна (112/58). Шалгалтын үр дүнд 2,047 зорчигчийг онилж шалган, 42 хууль бус эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах бодис, алт монетан эдлэл, татвартай бараа зэрэг хууль бус үйлдлийг таслан зогсоож, хариу арга хэмжээг авсан байна.		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					- Бичиг баримт, Хорио цээр, Хяналт шалгалтын үр дүнгийн саналыг хялбаршуулах програмын бодлогын даалгаврыг боловсруулан МТГ-т хүргүүлж, давхардсан үйл ажиллагааг бууруулж, дүн шинжилгээг дашбордоор харуулж, эрсдэл тооцох үр нөлөөг сайжруулах боломжийг бүрдүүлсэн. - Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдсан 71 ААН-д эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан.		
3 (11.3)	Гадаад худалдааг хөнгөвчлөх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	65%	Нэг. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр: - Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн Нэгдүгээр хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган гаалийн албан хаагчдын хүртээл болгохын зэрэгцээ Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, СЯ, ГХЯ-нд хүргүүлж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан. - Энэхүү тайланд тусгасан 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт авсан “Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах” арга хэмжээний хэрэгжилтийг ГХЯ ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хороонд хүргүүлж Монгол Улсын хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Хоёр. ДГБ-ын “Меркатор” хөтөлбөрийн хүрээнд - Монголын Гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд онош зүйн шинжилгээ хийсэн тайланд тусгасан 16 зөвлөмжийн хүрээнд 56 арга хэмжээг төлөвлөсөн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилт ирүүлэх дотоод зурвасыг ГЕГ-ын ЗБББНДБ-д хүргүүлж, нэгдсэн тайланг гаргасан. - Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн зарим заалтын хэрэгжилтийг Үндэсний хороонд хүргүүлэх тайланд тусган, СЯ, ГХЯ, ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Гурав. “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч”: - НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (ХХБХ)-ын Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж, уг системд нэвтрэх чиглэлээр сургалт зохион байгуулж, ГЕГ-ын ЗБББНДБ,	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					харьяа гаалийн газар, хороодын 34 шинэ хэрэглэгчийг уг системд бүртгэн, үйл ажиллагааг идэвхжүүлсэн. https://reformtracker.org/site/dashbord/66e577a1f5f38fcda70e3918?page=Dashboard. Хүрсэн үр дүн: ДГБ, ДХБ, НҮБ-ын ХХБХ, ОУВС, СЯ, ГХЯ, ЭЗХЯ, Европын Холбооны Монгол Улсын Гадаад худалдааг хөгжүүлэх төсөл болон ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороо, худалдаа эрхлэгч нартай 5 албан бичиг, 73 цахим захидал солилцон, 21 уулзалт, 3 сургалтыг цахим болон танхимаар хамтран зохион байгуулж, гаалийн байгууллагын цахим хуудас, НҮБ-ын ХХБХ-ын Худалдааг хөнгөвчлөх Шинэчлэлийн хөтөч программд 15 мэдээлэл бэлтгэн, олон нийтийн хүртээл болгон, дараах үр дүнд хүрсэн: - ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн нэгдүгээр хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээний хэрэгжилтийг дэлгэрэнгүй байдлаар ГХЯ-нд хүргүүлж, ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг болж, хэлэлцээрийн хэрэгжилтийг 86.4 хувиас 95.2 хувьд хүргэж, 8.8 хувиар нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. https://www.tfadatabase.org/en/members/mongolia. Дээрх тайланд 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт хүлээсэн “Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах” арга хэмжээний хэрэгжилт тусгагдсан. - Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагыг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хорооны 2025 оны 06 дугаар сарын 04-05-ны өдөр зохион байгуулсан уулзалтад танилцуулж, Монголын Гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон улсад сурталчилсан үр дүнд хүрсэн. - Худалдааг хөнгөвчлөх 36 арга хэмжээ, бусад асуудлыг дэлгэрэнгүй байдлаар тусгаж, хамтран ажиллаж, хэрэгжилтийн үнэлгээ хийх НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (ХХБХ)-ын “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч” системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж 79 хувийг 4 хувиар нэмэгдүүлж, хэрэгжилтийг 83.02 хувьд хүргэсэн. https://reformtracker.org/site/dashbord/66e577a1f5f38fcda70e3918?page=Dashboard.		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					- Уг системд өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 78 хэрэглэгч бүртгэгдсэнээс 44 Гаалийн байгууллагын хэрэглэгч идэвхтэй ажиллаж, 43 үүрэг даалгаврыг уг програмын дагуу бүртгэж, хэрэгжилтийг ханган, худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой 11 мэдээллийг оруулж, олон улсад Монголын туршлагыг түгээсэн үр дүнд хүрсэн. Өнөөдрийн 729 удаа өөрчлөлт хийж, 8,265 удаа уг системд хэрэглэгчид хандалт хийсэн нь Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны үйл ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулахад дэмжлэг болсон. - ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилт, Меркатор хөтөлбөрийн дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтээр ДГБ-ын “Худалдааг хөнгөвчлөх хөгжлийн загварын үнэлгээ”-ий матрицийн дагуу үнэлэхд 57 хувийг 23.7 хувиар нэмэгдүүлж 80.7 хувьд хүрч, “Дийлэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн” буюу 3 дугаар түвшинд хүрсэн үр дүнтэй байна.		
4 (11.4)	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 11.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50%	Нэг. Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмын төсөлд “Зорчигч, улс хоорондын шуудан илгээмжид эрсдэл тооцох” чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулах чиглэлээр харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажилласан. Хоёр. Гаалийн шинэчлэл төслийн хүрээнд үр дүнг тооцоход “Бараанд хийх шалгалтын хувь хэмжээг бууруулах” гэсэн ажил ГЕГ-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн үнэлгээ болон Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолд тусгагдсан. Энэ нь эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг тооцох шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй тул үндэслэлийг боловсруулж, ХШҮДАГ, ДХАБХ-т хүргүүлсэн. Түүнчлэн Сангийн яамны ХШҮХ-тэй уулзаж, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх чиглэлээр санал солилцсон. Хүрсэн үр дүн: - Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх журамд “Зорчигч, улс хоорондын шуудан илгээмжид эрсдэл тооцох” чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, сүүлийн хагас жилд КОЙКА-ийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх автоматжуулалттай уялдуулах боломжийг бүрдүүлсэн. - Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг үнэлэхдээ экспорт, импортоор ялган, гаалийн мэдүүлэг, барааны бичлэг, статистик дүн, татварын дүн болон эрсдэлийн шалгуурын үр нөлөөг тооцох эхлэлийг тавьсан.	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 3: НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
5 (11.5)	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	50 %	Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хэлтсийн албан хаагчид хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан.	01.01-06.10	100
					Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой хэрэгжүүлэх дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн жагсаалтыг нэгжийн түвшинд бүрдүүлж, хяналт тавин ажиллаж байна:		
					- Гаалийн тухай хууль; - Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратеги (2022.12.14, ГЕГ-ын даргын тушаал А/343); - Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам (2021.03.17, ГЕГ-ын даргын тушаал А/118); - Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам (2019, ГЕГ-ын даргын тушаал А/287, 2024.12.20, ГЕГ-ын даргын тушаал А/713); “Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” ЗГ-ын 178 дугаар тогтоол, 2023 он.		
					Хүрсэн үр дүн: Хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомжийн жагсаалтыг гарган, давхардал, хийдэл гарах эрсдэлийг бууруулсан. Түүнчлэн зарим хууль тогтоомжид байгаа эрсдэлийн удирдлагын үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтийн оновчгүй байдлыг сайжруулах боломжийг бүрдүүлсэн.		
6 (11.6)	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	40 %	- Дотоод зохион байгуулалт: Нэгжийн төлөвлөгөө, тайлан гаргах үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор албан хаагчид сар бүр хуваарийн дагуу бичиг хэрэг, тайланг хариуцаж, улирал, хагас жил, бүтэн жилд ГУАБ, дарга хамтран тайланг нэгтгэн, хөдөлмөр зохицуулалтын хуваарилалт хийж, хэрэгжилтийг хангаж байна. - Хүний нөөц: Тус хэлтэст ажиллах хүний нөөцийн дутагдалтай байдлыг бууруулах зорилгоор ГЕГ-ын дарга, ХНХ-т танилцуулж, харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албан хаагчдыг ГЕГ-т ажиллах хуваарийг гаргасан.	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					Мэдээллийн технологи: ЭУХ-ийн суурин компьютер, принтерийн ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлын эрсдэлийн судалгаа хийж “Эрсдэлийн удирдлагын систем болон барааг сонгон шалгах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл (2025-2027 он)”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэл, хэрэгцээ, шаардлагын талаар СХОГ-т 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01800/12 Дотоод зурвасаар хүргүүлсэн.		
					Хүрсэн үр дүн: - Хэлтсийн албан хаагчид ажлын уялдаа холбоог ханган, чиг үүргийн зарим ажил орхигдох эрсдэлийг бууруулсан. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удирдах төв байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын хооронд ажлын уялдаа холбоогүй байх эрсдэлийг бууруулж, нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг сайжруулсан. - Харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албан хаагчид ГЕГ-т ирж ажиллаж байгаа нь хэрэгжүүлэхэд хэцүү, оновчгүй, давхардсан шалгуур үзүүлэлтийг хамтран сайжруулан, шаардлагатай тохиолдолд шалгуурыг шинэчлэх саналыг хамтран гаргасан. Ийнхүү харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албан хаагчид ГЕГ-т ирж ажиллаж байгаа нь хэрэгжүүлэхэд хэцүү, оновчгүй, давхардсан шалгуур үзүүлэлтийг хамтран сайжруулан, шаардлагатай тохиолдолд шалгуурыг шинэчлэх саналыг хамтран гаргаж ажилласан үр дүнд хүрсэн.		
ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ЁСНЫ ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ							
7 (11.7)	Үүрэг, даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		50%	Нэг. Удирдлагаас ЭУХ-т өгсөн 11 зөвлөмж, 7 үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, ГЗДАС-ийн үүрэг даалгаврын биелэлтийг оруулсан. СЕРП-ийн “Үүрэг даалгавар”: Зөвлөмж ХШҮДАГ-ын 11; Цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг биелэлтийг ханган ажилласан. - ГЕГ-аас зохион байгуулсан 8 “Мэдээллийн цаг”-т албан хаагчид тогтмол хамрагдаж байна. - Тус хэлтэст ирсэн 274 албан бичгийн шийдвэрлэлт 93.2 хувьтай байна. Эдгээрээс 22 албан бичгийг холбогдох нэгжид шилжүүлсэн.	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					- Сургалт, зөвлөгөөн: Хэлтсийн албан хаагчид үндсэн чиг үүрэг болон удирдлагаас өгсөн чиглэлийн хүрээнд <i>35 уулзалт, сургалтад оролцож</i>, байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажилласан. Хоёр. ЭУХ-ээс харьяа гаалийн газар, хороодод ГЗДАС-ийн Үүрэг даалгавар цэсээр системийн хэмжээнд болон тухайн гаалийн газар, хороотой холбоотой 7 үүрэг далгавар өгч, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан. Хүрсэн үр дүн: - ХШҮДАГ-аас 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд өгсөн 11 зөвлөмжтэй хэлтсийн бүх албан хаагчид танилцаж, оны эхнээс давхардсан ажлыг төлөвлөхгүй байх, үр дүнгүй тайлагнах, арга хэмжээг орхигдуулах эрсдэлийг бууруулсан. Цаг үеийн шинжтэй болон бусад үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр ханган, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлсэн. Сангийн яамнаас ГЕГ-ын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн тайлангийн үр дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг хагас, бүтэн жилээр ирүүлэх хоёр үүрэг даалгаврын хугацаа болоогүй байна. - ХГГХ-д хүргүүлсэн 7 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, зөвлөмж, чиглэл өгч ажилласан нь системийн хэмжээнд эрсдэл тооцох үйл ажиллагааг сайжруулж, нэгдсэн бодлого, чиглэлээр ханган, эрсдэлийг удирдлагыг хэрэгжүүлэх журамд зорчигч, улс хоорондын шуудан илгээмжид хэрхэн эрсдэл тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, эрсдэлийн удирдлагыг сурталчлах брошур, зурагт хуудсыг нэгдсэн байдлаар түгээх боломжийг бүрдүүлсэн.		
ЗОРИЛТ 3: НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
8 (11.8)	Ажлын цаг ашиглалт				- Өөрийн болон хэлтсийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах хүрээнд Албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг харьцуулах, хөдөлмөрийн цаг зарцуулалтыг хэмжих ажлыг хэрэгжүүлсэн. - Тус хэлтсийн албан хаагчид цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийг хичээлд нь хүргэж өгөх, өвтэй хүн асрах, хол амьдардаг, орон тоо дутуу тул илүү цагаар ажилласны улмаас зарим тохиолдолд ажлаас хоцрох эрсдэл гарч байна. Хэдий тийм боловч ажлын 8 цагаас байнга илүү цагаар ажилладаг нь хоёр орон тоо дутуу байгаатай холбоотой.	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					Хүрсэн үр дүн: Үндсэн ажил болон цаг үеийн шинжтэй бусад ажилд зарцуулж буй цаг хугацааг “Хөдөлмөрийн цаг зарцуулалтыг хэмжих маягт”-ыин дагуу тооцоолж, ажлын цагийг үр дүнтэй ашиглахад дэмжлэг үзүүлсэн. Тус хэлтсийн албан хаагчид ажлын цагийн таслалтгүй.		
9 (11.9)	Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		50%	Харьяа гаалийн газар, хороодод ГЗДАС үүрэг даалгавар болон нэгдсэн апп группэд 48 албан хаагчийг бүртгэн 28 файл, 7 линк байршуулж, өдөр тутам мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, 7 удаа нэгдсэн сургалт, уулзалт зохион байгуулсан. Тус хэлтсийн албан хаагчид үндсэн чиг үүргийн болон цаг үеийн шинжтэй бусад байгууллагатай хамтарсан 7, ГЕГ-аас байгуулсан 11, нийт 18 ажлын хэсэгт орж ажиллаж байна. Энэ нь нэг талаас ажлын уялдаа холбоог хангахад дэмжлэг болж байгаа байгаа боловч, нөгөө талаас үндсэн чиг үүргийн ажилд зарцуулах хугацаа буурах, албан хаагчдыг илүү цагаар ажиллах эрсдэлд хүргэж байна. Хүрсэн үр дүн: - Харьяа гаалийн газар, хороодтой уялдаа холбоог сайжруулан ажилласнаар эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтыг цаг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн. - Нэг албан хаагч 2-7 ажлын хэсэгт орж ажиллан, ажлын хэсгийн ахлагчийн өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр биелүүлэн ажилладаг. Энэ нь үндсэн ажлын хажуугаар илүү цагаар ажиллах, амралтын өдрөөр гэртээ ажиллах гэх мэт эрсдэлийг бий болгодог. Хэдий тийм боловч төрийн албан хаагчийн хувьд ажлын хэсгийн ажилд идэвхтэй оролцон ажлаа уялдуулж байна.	01.01-06.10	100
ЗОРИЛТ 1. ХУУЛЬ ЁСНЫ ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ							
10 (11.9)	Байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	40%	Нэг. Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг Олон улсын стандартын байгууллагын Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт ISO 31000:2018, Монгол Улсын Эрсдэлийн удирдлагын стандарт 31000:2020 баримт бичигт үндэслэн хэрэгжүүлэх чиглэлээр харьяа гаалийн газар, хороод, Ёс зүйн дэд хороог мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
	стандартад нийцүүлэх				Хоёр. Дэлхийн худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байлгах тухай багц стандартын “Гааль-Бизнесийн түншлэл” тулгуур баганын хүрээнд ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх хүрээнд: - Бизнес эрхлэгчдэд сурталчлах: Гааль-бизнесийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор хууль сахилт сайн үндэсний үйлдвэрлэгч 15 аж ахуйн нэгж (МАК ХК, Тод оймс, Лоро Пьяно Монгол, Монголын экспортын кластерийн холбоо ТББ, Урбанек, Янмал, Есөн Од фүүдс гэх мэт)-д итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрт хамрагдах урилгыг хүргүүлж, хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан ААН-ийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангасан. - Цахим программд өөрчлөлт оруулах чиглэлээр: Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (АЕО)-ийн гаалийн бүрдүүлэлт хамгийн түрүүнд болон өөр өнгөөр бусад бүрдүүлэлтээс ялгарч харагдах байдлаар программд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг МТГ-т 2024.01.07-ны өдрийн 2025/10 Дотоод зурвасаар хүргүүлж шийдвэрлүүлсэн. - Гаалийн мэдээллийн удирдлагын систем (Cims.gaali.mn)-ийн Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж цэсний "Гадаадын гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж бүртгэх", "Дотоодын гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж бүртгэх" хэсгийн талбарт нэмэлт өөрчлөлт оруулах талаар мэдээллийг боловсруулж Аствижн ХХК-ийн мэргэжилтэнд хүргүүлсэн. - МТГ-т 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01800/131 дүгээр дотоод зурвасаар дараах асуудлыг хүргүүлсэн ба ХБГ-аар дамжуулан программын даалгавар ирүүлсэн тохиолдолд хэрэгжүүлэх боломжтой гэсэн хариуг /амаар/ өгсөн. "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг"-ийн 2 дугаар талбарт илгээгч аж ахуйн нэгжийн АЕО кодыг оруулах; Гаалийн байгууллагын цахим системд "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан орны АЕО хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээллийг нэр, хаяг, ялган таних код буюу АЕО код, итгэмжлэл олгосон огноо гэсэн" 4 үзүүлэлтээр бүртгэх; Ялган таних код буюу АЕО кодоор аж ахуйн нэгжийг таньж зохих хөнгөлөлтийг эдлүүлэх (дараалал харгалзахгүйгээр хяналт шалгалт хийх, 3 сард нэг удаа лабораторийн шинжилгээнд хамруулах). "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар"-т өөрчлөлт оруулах: ХБГ-аас МТГ-т 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01101/334 дугаар дотоод зурвасаар программын даалгаврыг хүргүүлсэн.		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					- СДШХ-т “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг”-ийн 2 дугаар талбар буюу илгээгч аж ахуйн нэгжтэй холбоотой мэдээлэл оруулах хэсэгт Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан орны АЕО хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжийн АЕО кодыг оруулах асуудлаар 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01800/133 дугаар дотоод зурвасыг хүргүүлсэн ба тус хэлтсээс дэмжсэн хариуг ирүүлсэн. - Сургалт: Монголын Увс хүнс ХХК, Лхамур ХХК, Агни ХХК, Монголиан кашимер ХХК, Гурван сор ХХК, Монголын гоо сайхны /косметикийн/ кластерийн 8 аж ахуйн нэгжийн 10 ажилтан, АПУ ХК-ийн гадаад худалдаа хариуцсан удирдлага, менежерийн албан тушаал бүхий 20 ажилтанд ГИААН хөтөлбөрийн талаар цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан. - Сурталчилгаа: Гаалийн байгууллагын https://customs.gov.mn/ веб сайт болон Монголын гааль фэйсбүүк хуудсанд дараах мэдээллийг нийтэлсэн. Гурав. Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр БНХАУ, БНСУ, Хонг-Конг, ОХУ, Тажикистан Улсын гаалийн байгууллагатай ГХАХ-ээр уламжлуулан 23 цахим захидал солилцож, 7 уулзалтыг зохион байгуулж, хамтран ажилласан: - Монгол, БНХАУ-ын гаалийн байгууллага Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (АЕО)-ийг Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг эрчимжүүлэх цахим уулзалт зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор хэрэгжүүлсэн. - ГХАХ-ээр уламжуулан БНСУ-ын гаалийн байгууллагатай “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-ийн хэрэгжилт, 2025 онд хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох цахим уулзалтыг 3 удаа хийсэн. - Беларусь Улстай байгуулахаар төлөвлөсөн ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн төсөлд өгөх саналыг Хуулийн хэлтэст хүргүүлсэн. - Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Гааль татварын газартай Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг байгуулах 2025 оны 04 дүгээр сараас эхлүүлсэн.		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					<u>Хүрсэн үр дүн:</u> · Эрсдэлийн удирдлагыг олон улсын стандарт (ISO 31000:2018)-ын дагуу хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж Гаалийн байгууллагын Авлигын эрсдэлийн зураглал гаргах аргачлалыг Ёс зүйн дэд хороо, Сургалтын төвтэй хамтран боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглан, Авлигатай тэмцэх газар, Ёс зүйн хороонд хүргүүлж, ГЗДАС-ийн Ёс зүйн дэд хороо талбарт байршуулж, Гаалийн байгууллагын Ёс зүйн эрсдэлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлж, сайн туршлагыг Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академитэй хуваалцсан. · ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний үйлдвэрлэл эрхлэгч 15 ААН-д урилга хүргүүлж, хөтөлбөрийг сурталчлан, 5 ААН-д удирдамжийг батлуулж, 2 ААН-ийн ажлын байрны үнэлгээ, баталгаажуулалтыг хийж, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан. Гаалийн төв лабораторид ИААН-ийн барааны дээжийг дараалал харгалзахгүй магадлан шинжилгээнд хамруулах, сорилтын дүн, дүгнэлт гаргах үйл ажиллагааг аль болох богино хугацаанд гаргах, магадлан шинжилгээний дүгнэлтийн хугацааг 3 сар хүчинтэй байхаар зохицуулалт хийж худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ГТЛ-оос магадлан шинжилгээний дүгнэлтийг 3 сар хүчинтэй байхаар гаргах болсноор бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулсан. Мал эмнэлгийн ерөнхий газарт “ИААН-ийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж чиг үүргийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэж, хялбарчлах арга замын шийдлийг олох” талаар хамтын ажиллагааг эхлүүлсэн. · Гадаад орны гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хүрээнд БНХАУ-ын ГЕГ-тай байгуулсан хэлэлцээрийг албан ёсоор эхлүүлж, хоёр орны Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан ААН 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс талуудын импортын бүрдүүлэлтэд хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн. ОХУ, Беларусь, Хонг-Конгийн Гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн.		

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
11 (11.9)	Цахим нэг цонхны системийг бий болгох ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	65%	ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан “Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон. Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэл, зөвшөөрлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна. Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлсэнээр гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бүрдүүлэхийг зорьж ажиллаж байна. Үүнд: - Гаалийн байгууллагын автоматжуулсан CEPS, CAIS системд нэмэлт хөгжүүлэлт хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн импортын мэдүүлгийг E-mongolia болон эмийн бүртгэл, мэдээллийн Licemed системээс цахимаар татаж, гаалийн бүрдүүлэлт хийдэг болгосон; - Онцгой албан татвартай барааны хяналтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрөл, онцгой албан татварын тэмдэгтэй холбоотой мэдээллийг ХХААХҮЯ, Татварын Ерөнхий газартай солилцох системийн хөгжүүлэлтийг хийлгэж байна; - Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан, ашигласан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг цахимжуулан, CAIS-т холбож, мэдээлэл солилцох системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд БОУАӨЯ-ны ОУА-тай хамтран ажиллаж байна; - ЗДХЯ болон ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвөөс олгож буй галт зэвсгийн тусгай зөвшөөрлийг цахимжуулах программын даалгавар боловсруулах, гаалийн байгууллагын автоматжуулсан системтэй холбох зорилгоор СМТТ УТҮГ, ЦЕГ-ын БХТ-тэй хамтран ажиллаж байна.	01.01-06.10	95

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					Цахим нэг цонхны ажлын хэсгийн хурлыг 2025 онд зохион байгуулаагүй. Цахим нэг цонхыг бий болгох зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулах ажил Эдийн засаг, хөгжлийн яам дээр хүлээгдэж байна. ГХЯ, ЭЗХЯ, СЯ-нд Цахим нэг цонхыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн тайланд дэлгэрэнгүй тусгасан.		
12 (11.9)	Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	30 %	1. "Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг ахисан түвшинд хүргэх төсөл"-д хамрагдах хүсэлтийг МТГ-тай хамтран 2023 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-д хүргүүлж, 2023, 2024 онд Техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийж уг төсөл 2025-2028 онд 5.6 сая ам. долларын өртөгтэй хэрэгжихээр болсон. 2. Монголын Гаалийн байгууллага БНСУ-ын "Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам"-ны "Хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар Монголын Гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл"-д хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн. БНСУ-ын Мэдээллийн технологийн концерцум (Data Innovator For a Better World B2EN Co.,Ltd) төслийг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр болж, хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурж, Сангийн яамаар уламжлуулан цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр "Хиймэл оюунд суурилсан үйлчилгээний багц болон Нейрон процессортой (NPU) серверүүд нь судалгаанд суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулах, гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг оновчтой болгох, эрсдэлийн удирдлагын системийг сайжруулах, хүнээс хамааралтай үйл ажиллагааг цахимжуулах, хууль ёсны худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг шинэ шатанд гаргах болно. Хүрсэн үр дүн: 1. "Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг сайжруулах төсөл"-ийг 2025-2028 онд хэрэгжүүлэх Хэлэлцээрийн протоколд Сангийн сайд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын ерөнхийлөгчтэй 2025 оны 06 дугаар сарын 26-нд гарын үсэг зурахаар төлөвлөж байна. Уг төслийн бүрэлдэхүүн хэсэгт	01.01-06.10	100

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
0	1	2	3	4	5	6	7
					”ГЕГ-ын Дата төвд мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, Чингис хаан Олон Улсын нисэх буудалд зорчигчийн дагалдах ачааг шалгах Радио давтамж бүхий пайзын систем (RFID Tag system)-ийг суурилуулах ажил багтсан. КОЙКА-ийн төслийн “Ажиллах зарчим”-ыг Монгол хэлнээ орчуулж, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах хүсэлтийг ГЕГ-аас Сангийн ямаар уламжлуулан хүргүүлсэн. Үүний үр дүнд Чингис хаан Олон Улсын агаарын тээврийн боомтод зорчигчийн дагалдах ачааг шалгах Радио давтамж бүхий пайзын систем (RFID Tag system)-ийг суурилуулах ажлын хүрээнд “Радио давтамж бүхий пайзын систем (RFID Tag system) бүхий ачаа шалгах систем суурилуулах, үүнд өнгөөр ялгасан хоёр төрлийн хаяг (шар – ерөнхий шалгалт, улаан – нарийвчилсан шалгалт) ашиглан сэжиг бүхий ачааг удирдах, мөн зорчигчийн гарах хэсгийн таазанд гурван ширхэг Радио давтамж (RFID) уншигч системийг суурилуулах” болно. 2. Энэхүү төсөл нь Гаалийн Ерөнхий Газрын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг орчин үеийн дэвшилтэт технологи, үйл ажиллагааны автоматжуулалт, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг нэгтгэн шинэчлэх замаар Монгол Улсын худалдааг хөнгөвчлөх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой. Гаалийн өдөр тутмын үйл ажиллагаанд хиймэл оюуныг ашиглах байгууллагын болон дата аналитикийн чадавхыг бэхжүүлэх” хүлээлттэй байна.		


ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
	1	2	3	4	5	6	7
1.	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан	Эрхэлсэн түшмэлийн сургалтад хамрагдсан байна.	Төрийн захиргааны “Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д хамрагдан №Е1651 гэрчилгээ авч, Шилдэг төгсөгч болсон. Сургалтын үеэр олж авсан мэдлэгээ тухай бүр хэлтсийн үйл ажиллагаанд хэрэглэж, хөгжүүлж байна.	01.01-06.10	100%

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
	1	2	3	4	5	6	7
2.	ДГБ-ын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны болон техникийн зөвлөхийн сургалтад оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдсан байна.	ДГБ-ын ИААН-ийн зөвлөхийн сонгон шалгаруулалтад оролцох сургалтад тэнцэн, Ази, номхон далайн бүс нутгийн орнуудаас ИААН хөтөлбөрийг хэрэгжүүлэх сайн туршлагаас суралцан, Хонг-Конгийн Гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах ажлыг эхлүүлсэн.	01.01-06.10	100%
3.	Ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж мэдээлэл түгээсэн байна.	- Удирдлагын академийн “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сэдэвт сургалтад хамрагдаж “Төрийн албан хаагчийн ёс зүйн үзэл баримтлал, Ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэх...” зэрэг 8 сэдвийн хүрээнд 16 цагийн хичээл судалсан (№Z0532, 2025.03.12); - Монгол Улсын Ёс зүйн хороо болон Удирдлагын академи хамтарсан “Ёс зүйн сургагч багш бэлтгэх” 16 хичээлийн хүрээнд 32 цагийн сургалтад хамрагдсан (№Z1433, 2025.05.26); - Сургалтаар олж авсан мэдлэгээ Ёс зүйн дэд хороодын гишүүд, хэлтсийн хамт олон, Удирдлагын багт түгээж, холбогдох танилцуулга бэлтгэн гаалийн албан хаагчдад дотоод сүлжээгээр дамжуулан түгээж, Гаалийн мэргэшлийн ёс зүйг хөгжүүлэхэд дэмжлэг болсон.	01.01-06.10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



(Д.ЦЭНДСҮРЭН)

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЦЭНДСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Эрсдэлийн удирдлагын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		63

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Арга хэмжээ 1. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах		15
2.	Арга хэмжээ 2. ДГБ-ын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны болон техникийн зөвлөхийн сургалтад оролцох		15
3	Ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдах		15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	14
2	Удирдан зохион байгуулах	13
3	Асуудал шийдвэрлэх	13
4	Манлайлах	13
5	Багаар ажиллах	13
6	Харилцаа	13
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		13

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	63
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		91,2

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч

(Р Отгонжаргал)

2025.06.25. (огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

/Эрсдэлийн удирдлагын
Хэлтсийн даргын албан үүргийг
Түр орлон гүйцэтгэгч/

(Д.Цэндсүрэн)

2025.06.10. (огноо)